

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

ИЛТГЭХ ХУУДАС

Дээд газраас ирсэн тогтоол шийдвэрийн 2022 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай

2022 оны 07 дугаар сарын 08

Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Эрх зүйн үндэслэл нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-т заасан шалгуур үзүүлэлт, аргачлалаар үнэлгээг гүйцэтгэв.

Журамд заасны дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Хууль эрх зүйн хэлтсээс ирүүлсэн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг уншиж танилцах, тухайн ажлыг хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж, ярилцах, холбогдох мэдээллийг ашиглан хийсэн.

ХОЁР. ДЭЭД ГАЗРААС ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Дээд газраас ирсэн тогтоол шийдвэрийг төрлөөр нь ангилбал:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг-3
2. Монгол Улсын хууль-2
3. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж-1
4. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хурлын тэмдэглэл-1
5. Монгол Улсын Их хурлын байнгын хорооны тогтоол-3
6. Засгийн газрын тогтоол-17
7. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл-8
8. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол-2
9. Нийслэлийн Засаг даргын захирамж-15 тус тус Сүхбаатар дүүргийн Засаг даргад хамаарах нийт 53 шийдвэрийг 2022 оны эхний хагас жилд хяналтад авч, холбогдох биелэлтийг гаргасан байна.

**ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН
ДЭЭД ГАЗРААС ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН СҮХБААТАР ДҮҮРЭГТ ХАМААРАЛТАЙ ЗААЛТУУДЫН ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО**

Хүснэгт 1.

№	Үнэлгээний ангилал	Үнэлгээн-ий хувь	Үнэлэх боломжит хувь	Нийт	Ерөнхийлөгч ийн зарлиг	Монгол улсын хууль	ҮАБЗ Зөвлөмж	ҮАБЗ-ийн хурлын тэмдэглэл	УИХБХ Тогтоол	ЗГ тогтоол	ЗГ-ын Хуралдааны Тэмдэглэл	НИТХ Тогтоол	НЗД-ын захирамж
Тогтоол шийдвэрийн тоо				53	3	2	1	1	3	17	8	3	15
Тогтоол шийдвэрийн заалтын тоо				76	3	9	1	1	3	25	11	3	20
1	“Бүрэн хэрэгжсэн”	100%	90-100%	21	2	1	1	1	1	6	2	3	4
2	“Хэрэгжих шатанд”	70%	50-89%	25		1			2	7	6		9
3	“Хэрэгжилт хангалтгүй”	30%	10-49%	7	1					4			2
4	“Хэрэгжээгүй”	0%	0-9%										
5	“Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”	-	-										
Нийт дундаж хувь				80%	77%	91%	100%	100%	67%	64%	66%	97%	62%

Дээд газраас тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нийт 53 шийдвэрийн 76 заалтын хэрэгжилтийн дундаж нь эхний хагас жилийн байдлаар 80%-тай хэрэгжсэн. Үүнээс “Бүрэн хэрэгжсэн” 90-100% хувьтай 21 шийдвэр, “Хэрэгжих шатанд” 50-89% хувьтай 25 шийдвэр, “Хэрэгжилт хангалтгүй” 10-49% хувьтай 7 шийдвэр байна.

**ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ ҮНЭЛЭГДСЭН 7 ШИЙДВЭРИЙГ ЖАГСААЛТААР
ТАНИЛЦУУЛБАЛ:**

Хүснэгт 2.

Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц (Хэсгийн дундаж: ...хувь)
Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг			
1	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-05-23 Дугаар 2018_46	4.Энэхүү зарлигт дурдсан ажлуудад болон монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гарган ажиллахыг иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагуудад уриалсугай.	Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III-ийг хэрэгжүүлэх хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн албан хаагчийн монгол бичгийн мэдлэг тодорхойлох судалгаанд нийт сургууль, цэцэрлэгийн 4700 гаруй албан хаагчид бүрэн хамрагдсан. Үндэсний хөтөлбөрийг сургуулиудад хүргэж, сургууль бүр төлөвлөгөө гарган ажиллаж байна. Монгол бичиг – III үндэсний хөтөлбөрийн хүрээнд Монгол бичгийн сургалтыг 150, 109 дүгээр цэцэрлэгийн багш, ажилчид нийт 32 иргэнд, 12 дугаар ангийн 10 суралцагчдад, Насан туршийн боловсролын төвийн багш, ажилтан албан хаагч 16 иргэнд, дүүргийн онцгой байдлын хэлтсийн 34 дүгээр ангийн алба хаагчдад тус тус зохион байгуулсан. Хэрэгжилт 30 хувь
Засгийн газрын тогтоол			
2	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2023-01-05 Дугаар 2022_7	5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх;	Сүхбаатар дүүргийн Ахмадын хорооноос санаачилсан ахмад багш нарыг хөдөлмөрийг дэмжих, төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдыг үндэсний монгол бичгийн сургалтад үнэ төлбөргүйгээр хамруулах "Үндэсний бичиг соёлоо сэргээе" төсөлд хамтран хороодын ажлын албаны албан хаагчдыг монгол бичгийн анхан шатны сургалтад хамруулж эхэлсэн. Эхний ээлжинд 4 хорооны 12 албан хаагч сургалтад хамрагдаж байна. Хэрэгжилт 20 хувь
3	Хөдөө аж ахуйн ээлжит тооллого явуулах тухай 2022-02-16 Дугаар 2022_74	3. Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг 2022 оны 5-7 дугаар сард багтаан зохион байгуулахаар тогтоосугай. Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг улсын хэмжээнд	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 74 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн Хөдөө аж ахуйн тооллого явуулах тухай А/751 дугаар захирамжийн дагуу тооллогын бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Үүнд: • Дүүргийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/223 захирамжаар Засаг даргын орлогчоор

		<p>Зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.</p> <p>3. Тооллогын ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулан хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг өрх, аж ахуйн нэгжийг тооллогод бүрэн хамруулж, тооллогын ажилд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>	<p>ахлуулсан дүүргийн Тооллогын комиссыг, 20 хороодод салбар Ажлын хэсгийг байгууллаа.</p> <ul style="list-style-type: none"> • Мөн тооллогын үйл ажиллагааны төлөвлөгөө, тоолох үе шатанд шаардагдах нэмэлт төсвийг батлуулж, бэлтгэл ажлыг хангаж байна. • Тооллогын бэлтгэл ажлын хүрээнд ҮСХ-ноос зохион байгуулсан сургагч багшийн сургалтад тус хэлтсийн дарга, 2 албан хаагчийг хамруулж, мөн тооллогоор ажиллах тоологч, шалгагчийг сонгон, тооллогын сургалтад хамруулав. • Тооллогоор ажиллах тоологч, шалгагчийг бэлтгэн сонгон, тооллогын сургалтад хамрууллаа. • Тооллогын нэгжийг тоологч нарт байршлаар нь жигд хувиарлан, НСГ-т хүргүүлэв. • Тооллогоор ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг баталж, Нийслэлийн Тооллогын комисст хүргүүлсэн. <p>Мал, тэжээвэр амьтдын 2022 оны тооллого оны эцэст явагдана.</p> <p>Хэрэгжилт 30 хувь</p>
4	<p>Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_204</p>	<p>1. Автомашины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, төрийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлж, тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд</p>	<p>Автомашины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, дүүргийн өмчид бүртгэлтэй автомашины жагсаалтыг Нийслэлийн өмчийн харилцааны газар болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж ажилласан.</p> <p>Одоогоор авто машин шилжүүлэх батлагдсан хуваарь, болон журам гараагүй тул авто машинуудыг хүлээлгэн өгөөгүй байна.</p> <p>Хэрэгжилт 30 хувь</p>

		татан төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нар тус тус даалгасугай.	
5	Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай. 2018-02-06 Дугаар 2018_43	1.1 нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар бүсчлэн хориглох арга хэмжээ авч, сайжруулсан түлшний хэрэглээг дэмжих, халаалтын бага, дунд, том оврын зуухнуудад эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй 4 технологийн шинэчлэлт хийх, халаалтын зуухнуудыг үе шаттайгаар төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох ажлыг 2018 онд багтаан зохион байгуулах	3 дугаар улиралд зохион байгуулна. Хэлтсийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд орсон болно. Хэрэгжилт 10 хувь
Нийслэлийн Засаг даргын захирамж			
6	2022.04.28 А/585 Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай	1.Нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилтын хүрээнд газар ашиглалтыг сайжруулах, авто замын түгжрэлийг бууруулах, явган хүний зам, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн зам, талбайг нэмэгдүүлэх зорилгоор хууль, журам зөрчсөн, стандартын бус хашаа, хайс барьсан	Тус захирамжийн хүрээнд 8 блокийн 188 байршилд 11906м хашааг чөлөөлөхөөр төлөвлөснөөс 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар нийт 35 байршлын 1223 м хашаа, хайсыг холбогдох хууль, журмын дагуу барьж, ашиглаагүй аж ахуйн нэгж, байгууллагуудад хуулийн дагуу мэдэгдэл хүргүүлж, зөрчлийг арилган ажиллалаа. Хэрэгжилт 20 хувь

		<p>газруудын зөрчлийг арилгаж, газар чөлөөлөх байршлыг хавсралт ёсоор баталсугай.</p> <p>2.1.хашаа, хайсыг холбогдох хууль, журмын дагуу барьж, ашиглаагүй аж ахуйн нэгж, байгууллагуудад хуулийн дагуу мэдэгдэл хүргүүлж, орчны аюулгүй байдлыг хангуулах, зөрчил арилгах, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба (Г.Батзориг)-нд;</p>	
7	<p>2022.02.17 А/212 Хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх тухай</p>	<p>1.Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь чанартай гүйцэтгэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг доор дурдсан байгууллага, албан тушаалтнуудад үүрэг болгосугай:</p> <p>1.1.мэргэжлийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж, тулгамдсан асуудлыг тухай бүр шуурхай шийдвэрлэх, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн бүхий л үе шатанд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагад;</p>	<p>Дүүргийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны худалдан авалтын төлөвлөгөөний дагуу худалдан авалтын захиалга 95.83%, худалдан авалт 73.02%, гэрээний хэрэгжилт 34.62%-тай хэрэгжиж, шат шатанд шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна.</p> <p>Хэрэгжилт 30 хувь</p>

Дүгнэлт: Дээд газраас ирсэн тогтоол шийдвэрээс Сүхбаатар дүүрэгт хамааралтай заалтуудыг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 6.3-д заасан хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл заалтын үнэлгээ тооцох аргачлалаар дүгнэхэд 2022 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн дундаж 80%-тай буюу “Хэрэгжих шатанд” байна гэсэн үр дүн гарсан бөгөөд үлдсэн хугацаанд “Хэрэгжилт хангалтгүй” үнэлэгдсэн шийдвэрийг эрчимжүүлж ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Дээд газраас ирсэн тогтоол шийдвэрийн Сүхбаатар дүүрэгт хамааралтай 53 шийдвэрийн 2022 оны эхний хагас жилийн тайланд хийсэн Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр дараах асуудлыг нийт хэлтэс, албад анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- Тоо болон чанарын үзүүлэлтийг нарийвчлан тусгах, ерөнхий өгүүлбэрээр биелэлт гаргахгүй болохыг анхаарах
- Нийслэлд хүргүүлэх тайланд “тус дүүргийн”, “дүүргийн” гэж оруулахаар бол өмнө нь “Сүхбаатар” гэж тодруулах шаардлагатайг анхаарах
- Дээд газраас ирсэн тогтоол шийдвэрийн хяналтад авсан шийдвэр, заалтын дэс дугаарлалтыг зөв хийх шаардлагатай.
- Албан хэрэг хөтлөлтийн стандарт, үг үсэг, утга найруулгын алдааг хянах, засаж сайжруулахад анхаарч ажиллана уу.

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА

Н.ЭНХБОЛД

ХЯНАСАН:
ТӨЛӨВЛӨЛТ ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

М.БЯМБАСҮРЭН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ИРГЭНИЙ ОРОЛЦОО
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Г.НЯМДОРЖ